

Российская академия наук
Институт восточных рукописей
(Азиатский Музей)



Адрес учредителя: 191181,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.

Адрес редакции: 191181,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.

Адрес издателя: 191181,
Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.

Тел.: +7 (812) 315-87-28
<http://orientalstudies.ru>
mongolica@orientalstudies.ru
kulgan@inbox.ru
dnosov@mail.ru

Регистрационный номер
свидетельства о регистрации
средства массовой информации
ПИ No ФС77-79202
от 22 сентября 2020 г.

ISSN 2311-5939

DOI 10.48612/IVRRAN/13ek-uf74-ka49

MONGOLICA

Санкт-Петербургский журнал монголоведных исследований

Том XXVIII • 2025 • № 3

Выходит 4 раза в год

Издается с 1986 г.

Учредитель: ФГБУН

Институт восточных рукописей РАН

Редакционная коллегия:

И. В. Кульганек, *главный редактор,*
доктор филологических наук (Россия)

Д. А. Носов, *секретарь редколлегии, кандидат*
филологических наук (Россия)

М. А. Козинцев, *помощник секретаря,*
кандидат исторических наук (Россия)

Г. Билгуудэй, *доктор филологических наук (Монголия)*

А. Бирталан, *доктор наук (Венгрия)*

Р. М. Валеев, *доктор исторических наук (Россия)*

Л. С. Дампилова, *доктор филологических наук (Россия)*

И. В. Зайцев, *доктор исторических наук, профессор РАН*
(Россия)

Ж. Легран, *доктор наук, профессор (Франция)*

В. Капишовска, *доктор наук (Чехия)*

Э. Мунхцэцэг, *кандидат филологических наук*
(Монголия)

С. Л. Невелева, *доктор филологических наук (Россия)*

К. В. Орлова, *доктор исторических наук (Россия)*

М. П. Петрова, *кандидат филологических наук (Россия)*

Р. Поп, *доктор наук (Румыния)*

Ц. Саранцацрал, *доктор филологических наук*
(Монголия)

Т. Д. Скрынникова, *доктор исторических наук, профессор*
(Россия)

С. Чулуун, *академик МАН (Монголия)*

Е. Э. Хабунова, *доктор филологических наук (Россия)*

Н. Хишигт, *кандидат исторических наук (Монголия)*

Н. С. Яхонтова, *кандидат филологических наук (Россия)*

Оригинал-макет – М. В. Алексеева

Литературные редакторы и корректоры – Д. А. Носов, И. В. Кульганек

Технический редактор – М. А. Козинцев

Подписано в печать 15.09.2025

Формат 60×90 1/8. Объем 7 печ. л. Заказ №

Тираж 300 экз.

Отпечатано в типографии ООО «Литография».

Адрес типографии: 191119, Санкт-Петербург, ул. Днепропетровская, д. 8,
лит. А, офис 14.

e-mail: info@litobook.ru

12+

© Институт восточных рукописей РАН
(Азиатский Музей), 2025

© Коллектив авторов, 2025

В НОМЕРЕ:

ИСТОРИЯ

- С. Мөнхсайхан.** Чингисийн чулууны бичгийн түүхэн үндсийг
Монголын Нууц Товчооноос сурвалжлах нь 5

ФИЛОЛОГИЯ

- О. К. Бабаева.** Целебный родник поэзии Николая Хатуева 14
- Ч. Заяасүрэн.** Тэмээний даллагын бичмэл хоёр судрын тухай 19
- Р. П. Сумба.** Рукописи и ксилографы на монгольском и тибетском языках
из фондов Национального Музея Тувы 30

ИЗ АРХИВОВ ВОСТОКОВЕДОВ

- С. С. Сабрукова.** Н. Э. Уланов (1867–1904) о подготовке экспедиции в Тибет
(по материалам АВ ИВР РАН) 37

НАУЧНАЯ ЖИЗНЬ

- А. А. Колесников, И. В. Кульганек.** Военное востоковедение на службе Отечеству.
К 80-летию Великой Победы (Санкт-Петербург, 23–24 июня 2025 года) 54
- Т. Д. Скрынникова.** [Рец. на]: Цендина А. Д. Жизнь, отраженная в текстах:
народная магия монголов (конец XVI — начало XX в.). Приметы, сонники,
гадательные книги, обереги, заклинания, моления.
М.: Изд. дом Высшей школы экономики, 2024. 536 с.
(Orientalia et Classica series. IX (LXXX))..... 60

RUSSIAN ACADEMY OF SCIENCES
Institute of Oriental Manuscripts
(Asiatic Museum)



191181, Russian Federation
Saint Petersburg,
Dvortsovaya Emb., 18
Phone: +7 (812) 315-87-28
<http://orientalstudies.ru>
mongolica@orientalstudies.ru
kulgan@inbox.ru
dnosov@mail.ru

MONGOLICA

Saint Petersburg journal for Mongolian studies

Vol. XXVIII • 2025 • No. 3

The journal is published four times a year.

Published since 1986

Founder: Federal State Institution of Science
Institute of Oriental Manuscripts of the Russian Academy
of Sciences

Editorial board:

I. V. Kulganek — *editor-in-chief, Dr. Sci. (Philology), Russian Federation*
D. A. Nosov — *secretary, Cand. Sci. (Philology), Russian Federation*
M. A. Kozintcev — *assistant secretary, Cand. Sci. (History), Russian Federation*
G. Bilguudei. *Dr. Sci. (Philology), Mongolia*
A. Birtalan. *Ph. D., Hungary*
S. Chuluun. *Academician of the Mongolian Academy of Sciences, Mongolia*
L. S. Dampilova. *Dr. Sci. (Philology), Russian Federation*
J. Legrand. *Dr. Sci., Professor, France*
V. Kapishovska. *Ph. D., Czech Republic*
E. E. Khabunova, *Dr. Sci. (Philology), Russian Federation*
N. Khishigt. *Ph. D. (History), Mongolia*
E. Munkhtsetseg. *Cand. Sci. (Philology), Mongolia*
S. L. Neveleva. *Dr. Sci. (Philology), Russian Federation*
K. V. Orlova. *Dr. Sci. (History), Russian Federation*
M. P. Petrova. *Ph. D. (Philology), Russian Federation*
R. Pop. *Ph. D., Romania*
Ts. Sarantsatsral. *Dr. Sci. (Philology) Mongolia*
T. D. Skrynnikova. *Dr. Sci. (History), Russian Federation*
R. M. Valeev. *Dr. Sci. (History), Russian Federation*
N. S. Yakhontova. *Cand. Sci. (Philology), Russian Federation*
I. V. Zaytsev. *Dr. Sci. (History), Professor of the Russian Academy of Sciences, Russian Federation*

IN THIS ISSUE:

HISTORY

Serjee Munkhsaikhan. Investigating the Historical Root of the Stele of Genghis Khan..... 5

PHILOLOGY

Olga K. Bavaeva. A Healing Spring of Poetry by Nikolay Khatuyev..... 14

Chuluun Zayasüren. Two of the Manuscript Sutra's for Camel "Dallaga" 19

Rita P. Sumba. Written Sources in Mongolian and Tibetan Language at the Collections
of the National Museum of the Republic of Tuva 30

ARCHIVES OF ORIENTAL STUDIES

Svetlana S. Sabrukova. Naran E. Ulanov (1867–1904) on Organizing an Expedition to Tibet in 1904
(From the Archives of Orientalists at the Institute of Oriental Manuscripts
of the Russian Academy of Sciences)..... 37

ACADEMIC LIFE

Alexander A. Kolesnikov, Irina V. Kulganek. Military Oriental Studies on the Service
of the Motherland: On the 80th Anniversary of the Great Victory (St. Petersburg, June 23–24, 2025)..... 54

Tatiana D. Skrynnikova. Review of the Book: Tsendina, Anna D. Life Reflected in Texts:
Folk Magic of the Mongols (Late 16th to Early 20th Centuries). Omens, dream books,
fortune-telling books, amulets, spells, and prayers. — Moscow: HSE Publishing House, 2024. —
536 p. — (Orientalia et Classica series. IX (LXXX))..... 60

С. Мөнхсайхан
Монгол Улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн

ЧИНГИСИЙН ЧУЛУУНЫ БИЧГИЙН ТҮҮХЭН ҮНДСИЙГ МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООНООС СУРВАЛЖЛАХ НЬ

Уйгуржин монгол бичгийн хамгийн эртний дурсгалд тооцогддог Чингисийн чулууны бичгийг дотоод гадаадын олон судлаачид галиглах, унших, орчуулах, үг хэллэгийг нь тайлбарлах зэргээр шинжлэх ухааны үндэстэй олон талын судалгаа хийж бүхэл бүтэн судалгааны өв бүрдүүлсэн байна. Хэдийгээр хорин хэдхэн үгээс бүтсэн холимог нийлмэл өгүүлбэр боловч ихэнхдээ орчин цагийн монгол хэлний утгаар ойлгосоор иржээ. Иймээс тус өгүүлэлд энэхүү бичээсний түүхэн үндсийг Монголын нууц товчооноос сурвалжлан үзэх нь олон асуудлыг илүү тодорхой болгоно хэмээн үзэж байна. Тухайлбал, сартуул иргэн гэж хэн бэ, дайдж уу уулж уу, хамаг монгол улс гэж улсын нэр мөн үү, ноёдыг уу ардыг уу гэх мэт олон асуудлыг сурвалжлан тодруулах боломжтой. Мөн тухайн цагийн уйгуржин монгол бичгийн бусад дурсгал болон Монголын нууц товчоотой харьцуулан үзэж үсэг зүйн онцлогийг тодорхойлсон байна.

Түлхүүр үг: Чингисийн чулууны бичиг, уйгуржин бичиг, Монголын нууц товчоо, Чингис ханыг, сартуул иргэнийг.

Зохиогчийн мэдээлэл: Сэржээгийн Мөнхсайхан, доктор (PhD), дэд профессор. Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэл шинжлэлийн салбарын эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан (Монгол Улс, Улаанбаатар) (munkhsaikhans@mas.ac.mn).

© Мөнхсайхан С., 2025

Монголчуудын гал голомт болсон газар нутаг нь Төв Азийн нүүдэлчин ард түмний олон зуун жилийн түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалан үлдсэн өлгий нутаг билээ. Тиймээс монгол нутгаас олдсон хөшөө дурсгал, хад чулуу, хөрсөн доороос нь илрүүлсэн археологийн олдвор зэрэг нь зөвхөн монголчуудын түүхэнд холбогдоод зогсохгүй тус газар нутагт амьдран сууж байсан бусад үндэстэн угсаатны түүх, соёлын судалгаанд хамаарах төдийгүй дэлхийн соёлын өвд зүй ёсоор ордог. Бидний өвөг дээдэс монгол үндэстний өвөрмөц онцлог бүхий олон тооны соёлын өв, дурсгалт зүйлийг бидэнд уламжлуулан үлдээсэн ба зөвхөн үсэг бичигтэй холбоотой гэхэд л олон зууг дурдаж болно. Нүүдэлчдийн амьдрах хэв маягтай холбоотойгоор монгол ном судрын цаасан хэвлэлээс гадна өргөн уудам газар нутагт нь олон тооны соёлын үл хөдлөх дурсгал хадгалагдан үлджээ. Түүний нэг нь дэлхийн монгол судлалд Чингисийн чулууны бичиг хэмээн алдаршсан, тэртээ

800 жилийн өмнө бичигдсэн гэрэлт хөшөө юм. Чингисийн чулууны бичиг буюу Хасарын дүү Есүнгэд зориулан бичсэн тус гэрэлт хөшөөний бичгийг, дотор нь тэмдэглэгдсэн түүхэн үйл явдалтай нь холбон 1224 (1225) онд бичсэн гэж үздэг.

Хэл хүмүүсийн харилцааны хэрэглүүр байдаг бол үсэг бичиг түүнийг үеэс үед уламжлан дамжуулагч нь болдог. Бидэнд уламжлан ирсэн олон тооны үсэг бичгийн дурсгалын ачаар эртний монголчуудын түүх, хэл, соёлын судалгаа амжилттай хийгдэж байна. Ийм бичгийн дурсгалуудыг

- монголчуудын зохиосон үсэг бичгээр тэмдэглэгдсэн
- өөр үндэстний үсэг бичгээр тэмдэглэгдсэн гэж хувааж болно. Ийм шалгуураар үзвэл, Чингисийн чулууны бичиг нь хөшөө чулуун дээр бичигдсэн уйгуржин монгол үсгийн хамгийн эртний дурсгал бол Монголын нууц товчоо нь өөр үндэстний буюу хятад үсгээр

тэмдэглэгдсэн бичгийн дурсгалд тооцогдоно. Хэдийгээр уламжилж ирсэн хэлбэр нь адилгүй боловч хоёул дундад эртний монгол хэлний хосгүй үнэт дурсгал учир үе үеийн монгол судлаачдын анхаарлыг татсаар иржээ. Хэл шинжлэлийн судалгаанд ашиглахад уул дурсгалт бичгүүд нь нэг нэгэнтэйгээ адилгүй өвөрмөц онцлогтой. Үүнд, Чингисийн чулууны бичиг нь эртний уйгуржин монгол бичгийн хэлний болоод үсэг зүйн онцлогийг хадгалсан бол Монголын нууц товчоо нь тухайн үеийн амьд ярианы хэлний байдлыг тэмдэглэсэн байдаг. Гэвч хоёул нэг цаг үеийн монгол хэлний дурсгал учир нэг нь нөгөөгөө нөхвөрлөх, ялангуяа Чингисийн чулууны бичиг шиг цөөн үг хэллэгтэй дурсгалт бичгийн утга агуулгыг зөв ойлгож тайлахад Монголын нууц товчоо ихээхэн үүрэгтэй. Учир нь хэл алгуур аажим боловч өөрчлөгдөн хувирч байдаг зүй тогтолтой, ингэхдээ хүмүүсийн ертөнцийг үзэх үзэл, танин мэдэхүйн сэтгэлгээ хөгжихийн хэрээр улам боловсронгуй болж, хөгжин өөрчлөгдөж байдаг. Иймээс эртний бичгийн дурсгалуудын үг хэллэг тодорхой мэт боловч утга агуулгыг орчин цагийн хэл, сэтгэлгээний түвшинд ойлгон тайлбарлаж болохгүй юм.

Уг гэрэлт хөшөөг анх олсон цагаас эхлэн гадаад дотоодын эрдэмтэд тайлан уншихаар оролдож, өөр өөрийн хувилбарыг санал болгожээ. Тэдгээр судалгааны бүтээлийг эмхэтгэн цуглуулж, судлан нийтэлсэн [Чингисийн чулууны бичгийн судалгаа, 2021] байдаг тул бид энэ тухай давтан нуршилгүй зөвхөн уг гэрэлт хөшөөний бичээсийн утга агуулгыг (зарим талаар хэлбэрийг) Монголын нууц товчооноос тодруулсан өөрсдийн судалгааны үр дүнг танилцуулж байна.

Хөшөөний бичиг нь таван мөр, нийт хорин нэгэн үгээс бүтсэн, холимог нийлмэл бүтэцтэй өгүүлбэр ажээ. Галиглан сийрүүлбэл,

Činggis qan-i

sartayul irge haulju bayuju qamuq mongyol ulus-un

noyad-i buya sojiqai quriysan-tur

Yisüngge ontudur-un yurban jayud qučin tabun aldas

tur ontutlay-a

болно. Өгүүлбэрийг утгат хэсгээр нь задалбал

- Чингис ханыг (мөр тэтгэсэн)
- сартуул иргэ уулж бууж (цагийн байц гишүүн өгүүлбэр)
- хамаг монгол улсын ноёдыг буха сочигай хуригсанд (энгийн өгүүлбэр)
- Есүнгэ онтодруун, гурван зууд гучин таван алдаст онтодлоо (энгийн нийлмэл өгүүлбэр) болно.

Судлаачид хөшөөн дээрх таван мөр бүхий бичвэрийг сэргээн уншиж, утгыг нь тайлахдаа голдуу эх бичвэрт тулгуурласан байдаг. Бидний үзэхээр уг хөшөөний бичвэрийг ижил цаг үед хамаарах бичгийн дурсгалтай харьцуулан судалбал түүний хэлбэр, утга агуулгыг илүү гүнзгий ойлгож тайлбарлах боломжтой хэмээн үзэж 1228 онд эхний арван дэвтрийг зохион дуусгасан Монголын нууц товчооны хэл найруулга, хэл зүйн онцлогтой харьцуулан үзэв. Үүнд:

1-мөр: Činggis qan-i

Чингисийн чулууны бичгийн талаарх анхны судалгаа нь түүнийг зөв сэргээн унших, эрдэм шинжилгээний орчуулга хийж судалгааны эргэлтэд оруулах зорилготой байв. Уг бичгийг судалсан бүх хүн эхний мөрөнд буй хоёр үгийг “Чингис хан” гэж сэргээн уншсан байна. Харин ард нь залгасан хэл зүйн нөхцөлийг харьяалахын тийн ялгал эсвэл заахын тийн ялгалын нөхцөл гэж хоёр өөрөөр сэргээсэн, олонх нь заахын тийн ялгал гэж үзсэн байна. Эдүгээ үүнтэй маргах зүйл үгүй байхаа. Харин тийн ялгалын утгыг тодруулах хэрэгтэй.

Хөшөөний бичгийн уул хоёр үг заахын тийн ялгалаар хэлбэржсэн боловч бүрэн бус, монгол бичгийн мөр тэтгэх ёсоор эхний эгнээнд салгаж бичсэн учир судлаачид түүнийг олон янзаар тайлбарласан байдаг. Тухайлбал, доктор (Ph.D) О. Самбуудорж “...хэрэв нэр үг харьяалахын тийн ялгалаар төгсвөл нэрийн холбоо, заахын тийн ялгалаар төгсвөл үйлийн холбоо бүтээх үүрэгтэй. Тэр цагт монгол хэлний зарим аялгуунд харьяалахын тийн ялгал, заахын тийн ялгалыг адил хэлбэрээр хэлэх тохиолдол байсан” гээд “Činggis qan-i suu aldar badartuyai” буюу “Чингис хааны суу алдар бадартугай” гэсэн бүрэн өгүүлбэрийн хураасан хэлбэр гэж үзжээ. Харин заахын тийн ялгал гэж үзвэл бүрэн өгүүлбэрийг сэргээн таамаглахад төвөг-

тэй “Чингис хааныг их хаан байхад энэ хөшөөг босгов” гэсэн хувилбарыг санал болгож байна гэжээ.[?] Тэгвэл академич Л. Болд “бидний үзэхээр бол хөшөөний бичиг нь нэг л хавсарсан нийлмэл өгүүлбэрээс бүтсэн, цагийн байц гишүүний харьцаа илэрхийлж буй гишүүн өгүүлбэрийн өгүүлэгдэхүүний үүрэг гүйцэтгэж буй Činggis qan гэдэг үг нь заахын тийн ялгалаар хэлбэржсэн, өөрөөр хэлбэл

- Чингис хааныг Сартуул иргэнийг дайлж эзэлж бүхүй цагт,
 - Хамаг Монголын ноёд хурсан,
 - энэ үеэр Есүнгэ 335 алд хол харвасан
- үйл явдлууд цувран өрнөснийг тэмдэглэсэн байна”[?] гэжээ. Үүний хамт тэрбээр энэхүү эхний мөрөнд буй хааны нэрийг ямар тийн ялгалаар хэлбэржүүлсэнд судлаачид төдий л анхаарал хандуулалгүй явж ирсэн, гэвч энэ бичгийн утгыг зөвөөр ухаарахад уул нөхцөлийн утга, үүрэг ихээхэн чухал гэдгийг онцолжээ [Чингисийн чулууны бичгийн судалгаа, 2021. Х. 93–94]. Үнэхээр ч “Чингис хан” гэдэг үгэнд залгасан заахын тийн ялгал ямар үүргээр хэрэглэгдэж, ямар утга илтгэж буйг тодруулах нь бүтэн өгүүлбэрийн утгыг зөв тайлахад зайлшгүй хэрэгтэй тул юуны өмнө дундад эртний монгол хэлэнд заахын тийн ялгал ямар утга, үүрэгтэй байсныг Монголын нууц товчооноос тодруулъя. Үүнд:

- Монгол хэлний заахын тийн ялгалын үндсэн үүрэг нь үйлэнд өртөгчийг заадаг. Монголын нууц товчоонд ч ийм үүрэгтэй байжээ. Жишээ нь, *Бас Шиги хутугу-ыг гүр улсын хулгайг гэсээж, худлыг мохоож, үхүүлдэхүн ёстныг үхүүл, алдуулдахун ёстныг алдуул хэмээн гүр дээрийн зарга түшив.* 203§;
- Мөн заахын тийн ялгал төрлийнх нь олон юмны нэрээс онцлон ялгасан [Лувсанвандан, 2010. Х. 178] утга илэрхийлдэг. Монголын нууц товчоонд үйлийн эзнийг онцолсон утгаар хэрэглэнэ. Жишээ нь, *Алтан ханыг соёрхвоос Монголын ханд эдүгээдэд (одоохондоо) элсэн зетье.* 248§, *Чингис хааныг соёрхвоос ба (бид) Тангуд иргэн өндөр дэрсний нөмөрт өсгөж олон тэмээд гаргаж хаа болгож өгсү.* 249§ гэх мэт.
- Мөн гишүүн өгүүлбэрийн (заримдаа гол өгүүлбэрийн) өгүүлэгдэхүүнийг заана.

Жишээ нь, *Мөн нохой жил Чингис хааныг татар иргэнд морилсонд Ван хан Мэргид иргэнд морилж Тогтога бэхийг Баргужин төхөм зүг үлдэж...* 157§, *Чингис хааныг дон-годоогүйеэ Бөртэ үжин орон дотор өндийж сууж, хөнжлийнхөө захаар өвчүүгээ түүдэж Отчигины уйлахыг үзэж нулимс алдаад өгүүлрүүн.* 245§ гэх мэт.

- Мөн дундад үеийн монгол хэлэнд¹ заахын тийн ялгалыг давхар хэрэглэж утга эрчимжүүлэх ёсон байв. Жишээ нь, *Мөн үхэр жил Чингис хаан зарлиг болруун, Сүбээдэйг төмөр тэрэгтийг Тогтога-ын Хуту, Гал, Чулуун тэрүүтэн хөвүүдийг инү нэхүүлэн илээрүүн.* 199§, *Бидний зарлиг давагсдыг биднээ танигдахун мэтсийг биднээ өгч илээдхүн.* 199§, *Бас гүр иргэний хувь хувилсныг зарга заргалсныг хөх дэвтэр бичиг бичиж...* 203§ гэх мэт.

Үүнээс үзвэл Чингисийн чулууны бичиг дэх “Чингис ханыг” гэдэг үгийн заахын тийн ялгал нь “Сартуул иргэ уулж бууж” (сартуул иргэнийг уулгалан довтолж буудаллан бүхүйд) гэсэн цагийн байц гишүүн өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн болно. Заахын тийн ялгал нь түүнийг онцлон ялгасан утга илтгэнэ. Өөрөөр хэлбэл, “Чингис ханыг сартуул иргэ уулж бууж” гэдэг цагийн байц гишүүн өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн нь Чингис хан бөгөөд түүний байгуулсан гавьяаг үнэлж, мөн түүнийг хүндэтгэн өргөмжилж Чингис хан гэдэг үгийг мөр тэтгэн салгаж бичсэн байна². Монголын нууц товчоонд “хаан” гэдэг үгийг “qa”, “qan”, “qahan”, “qaan” гэж, “Чингис хаан”-ыг Činggis qa’an, Činggis qahan, Činggis qan (255§) гэж тус тус галигласан байдаг. Эдгээр нь зөвхөн дундад үеийн монгол хэлэнд байсан авианы үзэгдлийг тэмдэглэсэн хэрэг бөгөөд утгын хувьд ялгаа байхгүй тухайлбал, 123-р зүйлд edüi üge bara[l]duju eyin aman aldaju Temüjin-i Činggis_qahan ke’en nereyi[t] čü qan bo[l]qaba. (Эдүй үг баралдаж ийн аман алдаж Тэмүжинг Чингис хаан хэмээн нэрийдэж хан болгов), 124-р зүйлд Činggis qahan bolu’at Bo’orču-yin de’ü Ögölei_čerbi qor a[q]saba. (Чин-

¹ Дундад үеийн монгол хэлэнд гэсний учир нь уул үзэгдэл Монголын нууц товчоо төдийгүй түүнээс хойш зохиогдсон Алтан товч, Гэсэр зэрэгт тааралддаг.

² Иймээс академич Л. Болдын санал зөв болно.

гис хаан болоод Боорчу-ын дүү Өгөлэй чэрби хор агсав) гэх мэтээр дурдсан нь үүний баримт болно.

2-р мөр: sartayul irge hauliju bayuju qamuq mongyol ulus-un

Хоёрдугаар мөрийн цагийн байц гишүүн өгүүлбэр нь хоёр хэсгээс бүтжээ. Үүнд,

- “Сартуул иргэ уулж бууж”
- “хамаг монгол улсын”

болно. Юуны өмнө Чингис хааны уул-галан довтолсон “Сартуул иргэ”-ний тухай тодруулъя. Монголын нууц товчоонд Сартуул гэж гурван удаа, Сартуул иргэн гэж арван гурван удаа тус тус гардаг [Мөнхсайхан, 2020. Х. 1139–1141]. Ингэхдээ 撒兒塔兀 хэмээн галиглаж, 回回 гэж орчуулжээ. Эдгээрээс үзвэл сартуул гэдэг нь “Сартуул иргэн”-д харьяалагдах аль нэг овог аймаг (Үрүнгэчи балгаснаас Ялавачи Масхүд нэртэн эцэг хөвүүд хоёр Хурумши овогтон сартуул ирж балгасны ёс төр Чингис хаанаа өгүүлж... 263§), мөн тэдний амьдран суух газар нутгийг (Бас түүний хойно Найманаас айж буруудаж Сартуулын газраа Чуй мөрөнөө Хар хитадын Гүр ханд одов зэ. 152§) хэлдэг бол “Сартуул иргэн” гэдэг нь дундад азийн нутгаар амьдарч байсан исламын шашинт улс иргэнийг, судлаачдын үзэж буйгаар Хорезмын улс [Монголын нууц товчоон, 2023, Х. 585]-ыг хэлдэг ажээ. Монголын нууц товчоонд гарах “иргэн” гэдэг үг нь дундад зууны монголчуудын нийгэм түүхийн болоод улс төрийн ойлголт бүхий өвөрмөц үг юм. Товчхон хэлбэл, орчин цагийн монгол хэлний “улс” гэдэгтэй адилхан утгатай байсныг Монголын нууц товчоонд гарах Индус иргэн, Багдад иргэн, Хитад иргэн, Тангуд иргэн, Хашин иргэн, Оросууд иргэн гэх мэт үгтэй харьцуулахад мэдэгдэнэ. Түүнчлэн 189-р зүйлд Таян ханы эх Гүрбэсү хатан “Монгол иргэн үнэр муутан хувцас барааттан бүлгэй. Ангид хол бүжү бүүтүгэй” гэж хэлсэн байдаг. Гэвч үүнээс гадна Монголын нууц товчоонд Найман иргэн, Жад иргэн, Татар иргэн, Олхунуд иргэн, Хиад иргэн, Хонгирад иргэн, Хэрэйд иргэн, Мэргид иргэн, Жүрхин иргэний тухай өгүүлдэг ба зохиолын үйл явдлаас үзвэл тэдгээр иргэнийг Чингис хаан хараахан өөрийн мэдэлд оруулаагүй байсан цагт ийнхүү хэлсэн байгаа нь дурдсан “ир-

гэн” нь өмнөхийн адил “улс” гэсэн утгатай бус харин Чингис хааны мэдэлд хараахан ороогүй бие даасан аймаг байсныг илэрхийлдэг.

Чингисийн чулууны бичгийн үсэг зүйн онцлогийн нэг нь “н” гийгүүлэгчийг үгийн эхэн, дунд, адагт хаа орсноос үл хамааран бүгдийг цэгтэй бичсэн байдаг. Зөвхөн “иргэн” гэдэг үгэнд цэг байхгүй учир “иргэ” гэж унших нь зөв юм. Монголын нууц товчоонд үгийн эцэст орсон “н”-тэй бараг бүх үг “н”-тэй “н”-гүй хоёр хэлбэрээр тохиолдож, “н”-тэй олонхдоо олон тоог, “н”-гүй нь ганц тоог заадаг. Жишээ нь,

adu'u-阿都兀/adu'un阿都温	“адуу”
aya-阿牙/ayan阿顏	“аян”
öki-幹乞/ökin幹勤	“охин”
gü'ü-古兀/gü'ün古温	“хүн”
eje-額者/ejen額種	“эзэн”

гэх мэт. Гэвч “Сартуул иргэн”-ий хувьд олон тоо байх ёстой атал “иргэ” гэсэн байгаа нь дундад үеийн монгол хэлэнд үе төгсгөх гийгүүлэгч, ялангуяа үгийн эцэст орсон үе төгсгөх гийгүүлэгч авиа тогтворгүй байж, ярианы хэлэнд хэлний хэмнэх зарчмын нөлөөгөөр ихэнхдээ гээгддэг байсны ул мөр бололтой. Тэрчлэн эртний монгол хэлэнд ганц, олны утга илэрхийлдэг байсан тогтолцоо нь дундад эртний монгол хэлэнд алдагдаж эхэлсний баримт байж болно.

Удаах үгийг бид уулж /hawul->ha'ulju/ (цэрэг зэвсгийн хүчээр дайран довтолох) гэж сэргээсэн ба Монголын нууц товчоонд энэ үг олонтоо гардаг. Үүнийг олонх судлаач (бараг бүгдээрээ) dauliju /дайлж/ буюу “уулгалан довтолж өөрийн эрхшээлдээ оруулах” гэдэг үг гэжээ. Гэвч дараагийн мөрийн төгсгөлд байх өгөх оршихын тийн ялгалын -dur нөхцөл, дөрөвдүгээр мөрөнд байх “tabun” зэрэг үгийн бичлэгтэй харьцуулбал дүрс адилгүй байна. Иймээс үүнийг dauliju биш ha'uliju, өөрөөр хэлбэл, нэгдүгээр үсэг нь өвөг монгол хэлний үеэс дундад үеийн монгол хэлэнд хувьсан ирсэн үгийн эхний сул шүргэх h гэж үзэв. Ийм жишээ монгол үсэгтэй Хуа и и юй-д тохиолддог бөгөөд тухайлбал, уг тольд hurul буюу “уруул” гэдэг үгийн h-ыг мөн ингэж бичсэн байдаг. Харин l үсгийн дараа бичигдсэн i нь уул үгийн ярианы хэлний авианы онцлогийг тэмдэглэсэн³ байж болно.

³ Учир нь энэ үед ярианы хэлэнд гарсан авианы олон ху-

Хоёрдугаар мөрийн хоёрдугаар хэсэг болох “хамаг монгол улсын” тухай судлаачид төдийлөн дурдсангүй. Түүхч Х. Пэрлээ энэ тухай “Хамаг улсын үеийн *Qatıq Monqol* нь Онон Хэрлэний эхэн урсгалаар нутаглагч монгол, тайжууд аймаг төдийг хэлж байсан ажээ. Чингис хааны үеийн *Qatıq Monqol* бол Алтай, Хянган уулсын хоорондох Цагаан хэрэм, Байгал нуурын завсар дахь олон монгол аймгийн бүгдийн нэр болсон байжээ” [Чингисийн чулууны бичгийн судалгаа, 2021. Х. 319] гэсэн нь уул гурван үгийг “Хамаг Монгол Улс”-ын нэр гэж үзсэн байна.

Дундад эртний монгол хэлний олонх үгс орчин цагийн монгол хэлэнд хэлбэрийн хувьд тэр хэвээр хадгалагдан уламжилсан боловч зарим үгэнд үгийн бүтцийн судалгаа хийхэд тэр цагт өөр утгатай байсан нь тодорхой болдог. Ийм үгийн жишээнд дурдсан холбоо оруулж болно. Бид өмнөх судалгаандаа Монголын нууц товчоонд гарах “хамаг улсыг байгуулруун” гэдэг үгийн утгыг ийм аргаар тодруулсан [Мөнхсайхан, 2023. Х. 186–191] бөгөөд энэхүү холбоо үг нь “хурааж цуглуулсан улс иргэнийг (өөртөө) байлгахын тулд” гэсэн утгатай хэмээн үзсэн билээ. Үүний адилаар “хамаг монгол улсын” гэдэг үгийг тайлбарлаж болох юм. Холбоо үгийн бүрэлдэхүүнд буй хамаг гэдэг үгийн утгыг нэгэнт тодорхойлсон (хамаг /qatı+q/ нь хамсан буюу “хурааж цуглуулсан”) тул “монгол улс”-ыг тодруулъя. Монголын нууц товчоонд монгол улс, монгол иргэн, монголжин улс гэсэн гурван үг гардаг ба жишээнээс үзэхэд

- монгол улс гэдэг нь зөвхөн монгол овог аймгийн ард иргэд буюу монголчууд (*Үнэн бээр хаан ах минь зөв эс болбоос олон монгол улс өнчрөхүн. 272§*)
- монголжин улс гэдэг нь монгол овог аймгаас гадна тэдний мэдэлд орсон бусад овог аймгийн хүмүүсийг хамтатгасан Чингис хааны байгуулсан улсыг (*Монголжин улсыг жившээрэн* (эмхлэн цэгцлэх) *барж Чингис хаан зарлиг болруун. 202§*) хэлжээ.

Өөрөөр хэлбэл, эхний холбоо үгийн “улс” нь “ард иргэд, хүмүүс” гэсэн утгатай бол хоёрдугаар үгийн “улс” нь “туурга тусгаар улс

үндэстэн /state/” гэсэн утгаар хэрэглэгджээ. Тиймээс 189-р зүйлд Найманы Таян ханы эх Гүрбэсү “*Монгол иргэн үнэр муутан, хувцас барааттан бүлгээ*” хэмээн өгүүлсэн хэсгийн “Монгол иргэн” гэдэг нь Гүрбэсү хатны зүгээс Найман Монгол хоёр бол тус тусдаа улс үндэстэн гэдгийг, Монголын нууц товчооны зохиогчийн зүгээс Чингис хааны байгуулсан улс нь тухайн цагт Азийн өргөн уудам нутагт оршин байсан бусад улс гүрний нэгэн адил бие даасан улс байсныг хэлсэн хэрэг юм. Өөрөөр хэлбэл, монголчууд өөрсдийгөө монгол улс, Чингис хааны байгуулсан улсыг “монголжин улс” гэдэг байсан ба бусад улс үндэстний хувьд “монгол иргэн” байв. “Монгол улс” гэдэг үгийн утгыг ингэж ойлговол Чингисийн чулууны бичгийн хоёрдугаар мөрт буй “хамаг монгол улсын” гэдэг нь “Чингис хааны хураан цуглуулсан монгол овог аймгийн хүмүүс” гэсэн санааг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл, хэрэв бичвэрт дурдсан “хамаг монгол улс” нь Чингис хааны байгуулсан Их Монгол Улсыг хэлсэн бол гэрэлт хөшөөний бичигт “монгол иргэн” гэж хоёрдугаар мөрийн Сартуул иргэнтэй адилхан, эсвэл Монголын нууц товчоонд дурдсанаар “монголжин улс” гэж бичих ёстой байжээ. Иймээс “хамаг монгол улсын” гэдэг нь “Чингис хааны хураан нэгтгэсэн монгол овог аймгийн хүмүүс” гэдэг нь тодорхой бөгөөд ийм санаагаар хэлсэн гэдгийг дараагийн мөрийн судалгаа давхар батлах болно.

3-р мөр: *noyad-i buya sojiqai quriysan-tur*

Чингис чулууны бичгийн 3-р мөр хамгийн балархай байдаг тул утгыг нь олон янзаар тайлах оролдлого хийжээ. Эхний үгийг “ноёдыг”, “ардыг” гэж хоёр янзаар сэргээжээ. Гэрэлт хөшөөний энэ хэсгийг эдүгээ сэргээх боломжгүй тул⁴ арын “хуригсанд” гэдэг үгийн утгын судалгаанд тулгуурлан сэргээн ойлгоё. Монголын нууц товчоонд “тал талаас цуглах” гэсэн утгатай, хэлбэр өөр *qurıqı, qıraqı* гэсэн хоёр үг гардаг. Энэ нь авианы хувирлаар үгийн сан хөгжин баяжих нэгэн арга бөгөөд ялгаа нь, нэг

вирал өөрчлөлтийг бичгийн хэлэнд журамлаж амжаагүй байсан.

⁴ Түүхч Х. Пэрлээ “Чингисийн чулууг бие тулж нүдээр үзэхэд тэр үгийг “arad-i” гэж унших аргагүй байлаа. Тэр үгийн эхэнд “no-” үсэг тод үзэгдэж байхаас гадна “no-”-ийн доор у үсэг мөн тод харагдах тул түүнийг г гэж унших ёсгүй болж билээ” гэжээ.

овог угсааны хүмүүс тал талаас цуглавал “хурих”, өөр өөр овог угсааны хүмүүс тал талаас цуглавал “хурах” гэж хэлдэг байжээ. Орчин цагт дурдсан хоёр үгийн утга уламжлан хадгалагдсан бөгөөд тухайлбал, “хурих” гэдэг үгийн утга “хурим найр”-д, “хурах”-ын утга “хурал цуглаан, хурал хуй”-д тус тус хадгалагдаж байна. Тиймээс хэрэв “хурсанд” гэж бичсэн бол “ардыг” байх нь зөв, харин “хуригсанд” гэсэн учир “ноёдыг” гэх нь зөв юм. Энэ үгийг өмнөх мөрийн “хамаг монгол улсын” гэдэг үгтэй холбоовол дэлгэрэнгүй холбоо үг бүтэх ба “хамаг монгол улсын ноёд” буюу Чингис хааны хураан цуглуулсан монгол овог аймгийг захирах ноёдыг хэлжээ. Энэ түүхэн үйл явдалд сартуулыг дайлахаар хамт явсан ноёдоос гадна монгол нутагтаа үлдсэн ноёд ч бас очиж [Пэрлээ, 1962. Х. 3–23] оролцсон гэдэг. Монголын нууц товчоонд Чингис хааны байгуулсан улсыг Чингис хаан болоод түүний залгамжлагч хөвүүд голлон захирч, Чингис хааны үүдний өмч боол буюу итгэлт нөхөд хийгээд хүлэг баатрууд, ураг холбосон хүргэд туслан захирч байсныг тодорхой өгүүлдэг. Тухайлбал, ерэн таван мянгадын ноёноор хэн хэнийг томилсныг 202-р зүйлд нэр дурдан тэмдэглэжээ. Иймд Чингис хааны алтан урагтай шууд болоод дам хамаатай олон ноёд цугласан тул “хурих” гэдэг үгийг хэрэглэсэн байна. Нөгөөтгээгүүр Чингис хаан Сартуул иргэнийг дайлан, буцах замд болсон үйл явдлын тухай өгүүлсэн тул Их Монгол Улсын ард иргэд цуглах боломжгүй юм.

Тэгвэл тэд юуны учир цугласныг тодруулъя. Гуравдугаар мөрөнд буй буца soġiqai гэдэг үгийг буца orġai (Г. И. Спасский, Я. И. Шмидт), буца suġiqai (Д. Банзаров), boγtuγoġiqar (И. Н. Ключин), буца ...oġiqaj (В. Л. Котвич), buqa suġiqai (Х.Пэрлээ), buqa-(s)uġiqai (Л. Амби), buqa surqai (Дов) гэх мэтээр сэргээжээ. Харин утгын хувьд голдуу газрын нэр гэж үзсэн бол судлаач П. Аюушжав алтай хэлний баримт хэрэглэгдэхүүнтэй харьцуулан арай өөрөөр үзэх боломжтой гээд buqa, soġiqu гэсэн үгтэй холбон үзжээ. Тэрбээр уг хоёр үгийг газрын нэр гэхэд эргэлзээтэй, хэрэв газрын нэр бол өгөх оршихын тийн ялгалын нөхцөл залгах ёстой. Иймээс уг хоёр үг арын үйл үгтэйгээ хамт нэг утга илтгэж байна гээд Алтан товч, Асрагч нэртийн

түүх зэрэг сурвалжид “...ийм нуман түлхүүрт бух сэжүүр сайн билээ” гэж дурдсанд үндэслэн тэр үеийн цэргийн тактик, үйл ажиллагааны нэр байж болох юм гэсэн санал дэвшүүлжээ (2004) [Чингисийн чулууны бичгийн судалгаа, 2021. Х. 93]. Түүний энэ саналыг дэмжиж, зарим зүйлийг тодруулан академич Л. Болд “Буца soġiqai” газрын нэр үү [Болд, 2017. Х. 235–240] гэсэн нэртэй эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлжээ. Тэрбээр монголчуудын дайн байлдаан, ан авд хэрэглэдэг байсан арга, тактикийн талаар баримт дурдан “Буха сочигай” хэрэв газрын нэр үзвэл “хурь” гэдэг эс тусах үгээр илэрсэн, үйлийн болох орны харьцааг заасан өмнөх нэр үг яагаад тийн ялгалын нөхцөлгүй байна вэ? гэдэг асуулт зүй ёсоор гарч байна. Энэ бол “Буха сочигай” газрын нэр биш, цэргийн дайны тактикийн нэр гэдгийг батлах баримт гэж үзэхэд хүргэж байна гэжээ. Тиймээс түүний хэлсэн саналыг шалгаж үзэх хэлний баримтыг Монголын нууц товчооноос хайж үзвэл, тухайн үйлийн болох орныг заасан нэр үг

1. Өгөх оршихын тийн ялгалаар хувилдаг. Жишээ нь, *Би бээр хөдөлж Эдэр Алтайн бэлчрээр гэтэлж ирж Саарь хээрээ буув зэ. 177\$, Тэндээс Чингис хаан харьж Арай-аар давж ауругуудад буувай.* 198\$,
2. Заахын тийн ялгалаар хувилж байна. Жишээ нь, *Зөв тэнд Чингис хаан Тэмээн хээрийг авлаж Түлхин чэгүдийг хоморч бүхүйд Алахуш дигид хури-ын илээсэн Юхунан элч энэ хэл хүргэн ирэв. 190\$, Тэр өвөл зэргээр нүүж Чингис хаан Хуба хая-ыг өвөлжив.* 151\$,
3. Тийн ялгалын нөхцөлгүй. Жишээ нь, *Улс иргэнийг ану хөдөлгөж ирж Чингис хаан Хуба хая өвөлжвэй. 148\$, Тэндээс Чингис хаан хөдөлж Эдэр Алтайн бэлчрээр гэтэлж тэр хөдөлсөөр хөдөлж Саарь хээр буувай. 161\$, Чингис хаан Хо си вү-ыг буугаад Жунду-ын Шар хээр буув.* 252\$

Ажиглан үзвэл, гурав дахь тохиолдлын эхний жишээ өгүүлбэрийн орны харьцаа заасан нэр үг тийн ялгалын нөхцөл аваагүй мэт боловч, энэ нь хоёрдугаар жишээнд илэрсэн заахын тийн ялгалын “-ыг” нөхцөл, гуравдугаар жишээнд тэг хэлбэрээр илэрсэн болох нь мэдэгдэж байна. Мөн 161, 252-р зүйлд дурдсан

жишээ нь дундад үеийн монгол хэлэнд орны харьцаа заасан нэр үгийг бас өгөх оршихын тийн ялгалгүй бичиж болдог байсны баримт юм. Ийм жишээ Монголын нууц товчоонд олон буй. Тиймээс орны харьцаа заасан нэр үг өгөх оршихын тийн ялгалаар хувилахгүй байгаа нь газрын нэр гэдгийг баталж байгаа бус харин монгол овог аймгийн ноёд “хурих” болсон шалтгаан, гэрэлт хөшөө босгох болсон шалтгааныг бичвэрт тун тодорхой өгүүлсэн, тухайлбал Сартуул улсыг мөхөөсөн, энэ үйл явдлыг тэмдэглэн цэрэг эрсийнхээ урам зоригийг хөгжөөн монгол ноёдын хүч чадлыг сорьсонд Хасарын хүү Есүнгэ ер бусын хол харвасан нь олон хүний гайхшируулсан онцгой явдал болсон зэрэг нь “Буха сочигай” цэрэг тактикийн тэмцээн байсныг илтгэнэ. Өөрөөр хэлбэл, энэ үйл явдал хаана болсон нь чухал бус харин чухам яагаад олон ноёд харвалдан хүч үзэх болсон шалтгаан нь чухал гэдгийг бичвэрийн агуулга өөрөө тодорхойлж байна.

4-р мөр: *Yisüngge ontudur-un yurban jāyud qučīn tabun aldas*

5-р мөр: *tur ontutlay-a*

Хөшөөний бичгийн 4,5-р мөр нийлээд нэг өгүүлбэр болох ба галигласан байдлыг үзвэл “онтдох” гэдэг үгээс бусдыг судлаачид адилхан ойлгосон байдаг. Монголын нууц товчоонд ийм бүтэцтэй өгүүлбэр олон буй. Жишээ нь,

- *Олон дайсанд уулруун хамт нэгнээ уулъя* (olon dayyisun-ṭur ha'ulurun qamtu niken-e ha'uluṣa 164§)
- *Бас Таян хан Жамухадаас асууруун “Бас тэр хойноос зузаанаа айсухун хэн буюу” хэмээн асуув.* (basa Tayang_qan Jāmuqa-dača asaḡurun basa tere qoyina-ča juja'an-a ayisuqun ken būyū ke'en asa[q]ba 195§)
- *Анд соёрхож алуулруун, цус үл гарган алуул.* (anda soyurqaju ala'ulurun čisu ülü qarqan ala'ul 201§)
- *Тэнд Бурхан уулзруун алтан сүмс тэрүүлэн алтан мөнгөн аяга сав есөн есөд, нугад охид есөн есөд, агтас тэмээд есөн есөд, элдвээр есөн есөд зүсэлж уулзахуйд Бурханыг үүдэн бүтэгүүеэ уулзуулав.* (tende Burqan a'uljarun altan sümes teri'ülen altan mönggün ayaqa saba yisün yisüt nu'ut ökit yisün yisüt aqtas temeet yisün yisüt eldeb-iyer yisün yisüt

jisüleju a'uljaqui-ṭur Burqan-i e'üten bütē'üy-e a'ulja'ulba 267§)

- *Бас бид элчин уулруун, улс бидүүлэн уулгамуй.* (basa bida elčīn ha'ulurun ulus bitü'ülün ha'ulqamui 279§) гэх мэт. Тиймээс энэ бол дундад үеийн монгол хэлний бичгийн хэлний найруулгад түгээмэл байсан найруулан бичих арга байжээ.

Энэхүү өгүүлбэрт гарах “онтдох” гэдэг үгийг бичээсийн утгыг тайлах анхны оролдлогыг хийсэн хүмүүс “хондогор” гэж сэргээсэн байсныг И. Н. Клюкин “ontodor-un” гэж, сүүлийн үгийг мөн “ontoduluṣ-a” гэж уншсан нь Чингисийн чулууны бичигт өгүүлсэн үйл явдлыг зөвөөр ойлгож тайлах эхлэл болсон байдаг. Харин утгын тухайд “зөв тусах” (Х. Пэрлээ), “мэргэн онолоо” (Г.Гантогтох), оногдов (Д. Банзаров), “холын зайнаас харвах” (Ж. Лувсандорж), “он тусах байр буюу газар” (Л. Болд) гэх мэтээр тайлбарлажээ. Үгийн утгыг тодорхой мэдэхийн тулд юуны өмнө үгийн бүтцээр задалж үзье. Үүнд, ontudu+run/ ontudu+luṣ-a болох бөгөөд -run нь дундад үеийн монгол хэлэнд идэвхтэй хэрэглэгдэж байсан -хдаа гэсэн утгатай үйлийн холбох нөхцөл бол luṣ-a нь үйлийн өнгөрсөн цагаар төгсгөх нөхцөл юм. Тэгвэл үгийн үндэс буюу ontudu- нь ямар утгатай болохыг мөн Монголын нууц товчооны жишээнээс тодруулъя. Үүнд 244-р зүйлд “*Огжтож гарсныг онтцож оруулах бүлгээ*” 254-р зүйлд “*Онтцож чамд гартваас эрхийгээ огтолж оорсугай*” гэх мэт жишээнд гарах “hontuṣa-”-ыг үгийн бүтцээр задалж үзвэл үгийн үндэс hontu-⁵ нь “онтдох”-той гарал, утга адил болох нь харагдаж байна. Уул үгийг хадмал орчуулгад эхний өгүүлбэрт 遠箭射着 (хол харваж), хоёрдугаар өгүүлбэрт 賽箭射着 (тэмцэлдэн харваж) гэснийг үндэслэн үгийн утгыг “сум тусах хамгийн хол зайд харвах” гэж ойлгож байна. Өөрөөр хэлбэл, тухайн үед “онтдох” гэдэг үгэнд оновчтой харвах (хожим нь энэ утга нь давамгайлсан байж болно)-аас илүүтэй “хамгийн хол зайд харвах” гэсэн утга давамгайлж байжээ. Үүний нотолгоо нь Чингисийн чулууны бичиг хэмээн нэрлэгдсэн энэхүү гэрэлт хөшөөг босгох болсон шалтгаан нь Хасарын дүү Есүнгэ 335 алд

⁵ -ца бүтээвэр нь уг үйл харилцан болсон утгыг заана.

газар хол харвасан явдал гэдгийг хөшөөний бичигт тодорхой дурдсан байдаг.

Гэрэлт хөшөөний бичээсийн үсэг зүйн онцлогоос товч дурдвал, уйгуржин монгол бичгийн бусад дурсгалуудад байдаггүй хэд хэдэн зүйл байна. Тухайлбал, “н” гийгүүлэгчийг үгийн хаана ч тохиолдсон цэгтэй бичсэн, q/ү-ыг ялгасан, дэвсгэр үсгийг ялгасан, дундад үеийн ярианы хэлэнд байсан зарим авианы үзэгдлийг тэмдэглэсэн (хоёр эгшгийн дундах гийгүүлэгч гээгдсэн, үгийн эхэнд байсан сул шүргэх h-г тэмдэглэсэн) зэргийг дурдаж болно. Гэвч энэ нь тогтолцоотой бус тухайлбал,

- “ontodor-un” гэдэг үгэнд дэвсгэр үсгийг ялгаж тэмдэглэсэн бол “ontoduluγ-a”-д ялгаагүй,
- ha'ulijū гэдэг үгэнд үгийн эхний сул шүргэх h-г тэмдэглэсэн бол ontodor-un, ontoduluγ-a-д тэмдэглээгүй,
- ha'ulijū гэдэг үгийн хоёр эгшгийн дундах гийгүүлэгч гээгдсэн бол sartayul-д гээгдээгүй гэх мэтийг дурдаж болно. Бичигт илэрч буй хэл зүйн энэхүү түүхэн баримт нь тухайн цагт аль нэг овог аймгийн тодорхой хүрээнд хэрэглэж байсан уйгуржин монгол бичгийг нийт монголчуудын үсэг бичиг болгохын тулд зайлшгүй шинэчлэн сайжруулах шаардлагатай байсныг илтгэн харуулж байна.

Төгсгөлд нь тэмдэглэхэд, Чингисийн чулууны бичиг хэмээн нэрлэгдсэн энэхүү гэрэлт хөшөөний бичвэрийг уйгуржин монгол бичгийн хамгийн эртний дурсгал болохынх нь хувьд хэл шинжлэлийн талаас шинжлэн дүгнэвэл, бичвэр хэдийгээр нэг л өгүүлбэрээс бүтсэн боловч тухайн үеийн бичгийн хэлний найруулга хэр өндөр түвшинд байсныг илтгэсэн, түүнчлэн илэрхийлж буй санаагаа өгүүлбэр зүйн аргаар маш оновчтой бөгөөд ойлгомжтой илтгэсэн (холимог нийлмэл өгүүлбэрээр) монгол хэл сэтгэлгээний гайхамшигт дурсгал юм. Тиймээс бичвэр дэх үг хэллэгийн утгыг зөв ойлгож тайлбарлах нь түүний үнэ цэнийг улам нэмэгдүүлэх нь лавтай.

Төгсгөлд нь тэмдэглэхэд, Чингисийн чулууны бичиг хэмээн нэрлэгдсэн энэхүү гэрэлт хөшөөний бичвэрийг уйгуржин монгол бичгийн хамгийн эртний дурсгал болохынх нь хувьд хэл шинжлэлийн талаас шинжлэн дүгнэвэл, бичвэр хэдийгээр нэг л өгүүлбэрээс бүтсэн боловч тухайн үеийн бичгийн хэлний найруулга хэр өндөр түвшинд байсныг илтгэсэн, түүнчлэн илэрхийлж буй санаагаа өгүүлбэр зүйн аргаар маш оновчтой бөгөөд ойлгомжтой илтгэсэн (холимог нийлмэл өгүүлбэрээр) монгол хэл сэтгэлгээний гайхамшигт дурсгал юм. Тиймээс бичвэр дэх үг хэллэгийн утгыг зөв ойлгож тайлбарлах нь түүний үнэ цэнийг улам нэмэгдүүлэх нь лавтай.

Ашигласан ном зүй

Болд, 2017: *Болд Л. Вича соџіцаі* газрын нэр үү // Үсэг бичиг, үг хэллэгийн судалгаа. Соёмбо принтинг хэвлэлийн компани. Улаанбаатар, 2017.

Монголын нууц товчоон, 2023: *Дэлгэрэнгүй тайлбартай* Монголын нууц товчоон. Сэлэнгэ пресс хэвлэлийн компани. Улаанбаатар, 2024.

Лувсанвандан, 2010: *Лувсанвандан Ш.* Монгол хэлэн дэх ялгах үл ялгахын ёс // Шадавын Лувсанвандангийн бүтээлийн чуулган VII “Монгол хэлний бүтээвэр, үг, өгүүлбэрийн судлал”. Соёмбо принтинг хэвлэлийн компани. Улаанбаатар, 2010.

Мөнхсайхан, 2020: *Мөнхсайхан С.* Монголын нууц товчооны үгийг эшлэн үзүүлсэн толь. Бэмби

сан хэвлэх үйлдвэр. Улаанбаатар, 2020.

Мөнхсайхан 2023: *Мөнхсайхан С.* Монголын нууц товчооны утга зүй, соёл, сэтгэлгээ. Соёмбо принтинг хэвлэлийн компани. Улаанбаатар, 2023.

Пэрлээ, 1962: *Пэрлээ Х.* Чингисийн чулууны бичээс // Пэрлээ. Гурван өгүүлэл Studia Mongolica Т-III ШУА-ийн хэвлэх. Улаанбаатар, 1962.

Чингисийн чулууны бичгийн судалгаа, 2021: Чингисийн чулууны бичгийн судалгаа. 200 жилийн түүх: судлаач, бүтээл, тайлбар (Судалгааны тойм бичиж, ном зүй үйлдэж, бүтээлүүдийг эмхэтгэсэн Б. Түвшинтөгс) Соёмбо принтинг хэвлэлийн компани. Улаанбаатар, 2021.

INVESTIGATING THE HISTORICAL ROOT OF THE STELE OF GENGHIS KHAN

Serjee MUNKHSAIKHAN

Institute of Language and Literature, Mongolian Academy of Sciences

Many researchers have been making scientific investigations to transcribe, to read, to translate, to interpret and build a whole database about the Stele of Genghis Khan, considered to be the oldest record of Uyghur-Mongol script. Although it is composed of compound segments that contain a few words, this article proposes that investigating its historical roots from the Secret history of the Mongols will answer many questions. In particular, the questions of who are the Sartayuls, if Khamag Mongol is a state's name, if its read 'noyad-i' or "arad-i" and "dauliju" or "ha'ulju" could potentially be investigated from the Secret History of Mongols. Moreover, comparing other records of the Uyghur-Mongol script and the Secret History of the Mongols is useful for studying philological aspects.

Key words: Mongol, Uyghur script, Genghis Khan, Yesunge, The Secret history of the Mongols.

About the author: **Serjee MUNKHSAIKHAN**, PhD, Assistant Professor, Leading Researcher at the Department of Linguistics, Institute of Language and Literature, Mongolian Academy of Sciences (Ulaanbaatar, Mongolia) (munkhsaikhans@mas.ac.mn).